



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Европын сэргээн босголт хөгжлийн банк, Япон улсын Жайка олон улсын байгууллагын буцалтгүй тусламжаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт 50 МВт-ын чадалтай "Цэций" салхин станцыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох 110/35/10 кв-ын "Тавантолгой" дэд станцын өргөтгөлийн барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон хавсралтад заасан 19 нэрийн нийт 792,031,100.00 (долоон зуун ерэн хоёр сая гучин нэгэн мянга нэг зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

0000170

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дугаар сарын 10 ны өдрийн
66 дугаар тогтоолын хавсралт

**"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хүчин чадал		Нэг бүрийн үнэ /төгрөгөөр/	Балансын үнэ /төгрөг/
			хэмжих нэгж	биет хэмжээ		
1	Хийт таслуур	2017	иж бүрдэл	2	120,000,000.00	240,000,000.00
2	Хуурай салгуур	2017	иж бүрдэл	2	31,000,000.00	62,000,000.00
3	Хуурай салгуур	2017	иж бүрдэл	2	35,000,000.00	70,000,000.00
4	Хуурай салгуур	2017	иж бүрдэл	2	28,000,000.00	56,000,000.00
5	Хүчдэлийн хувьсгуур	2017	иж бүрдэл	2	17,000,000.00	34,000,000.00
6	Гүйдлийн хувьсгуур	2017	иж бүрдэл	6	15,000,000.00	90,000,000.00
7	Цэнэг шавхагч	2017	иж бүрдэл	6	7,000,000.00	42,000,000.00
8	РХА шилэн нүүртэй памель	2017	иж бүрдэл	2	5,000,000.00	10,000,000.00
9	Микропроцессор реле	2017	иж бүрдэл	2	28,000,000.00	56,000,000.00
10	Микропроцессор реле	2017	иж бүрдэл	2	30,000,000.00	60,000,000.00
11	Микропроцессор реле	2017	иж бүрдэл	2	3,000,000.00	6,000,000.00
12	SATEC	2017	иж бүрдэл	2	1,500,000.00	3,000,000.00
13	3 фазын электрон тоолуур	2017	ш	2	2,500,000.00	5,000,000.00
14	СК-2G багана (Шат тавцангаар тоноглогсон)	2017	ком	1	13,000,000.00	13,000,000.00
15	Шинийн порталын төмөр хийц	2017	ком	2	1,090.55	2,181,100.00
16	Шугамын порталын төмөр хийц	2017	ком	1	1,250,000.00	1,250,000.00
17	Тоноглолын бетон хийцүүд	2017	ш	59	705,085.00	41,600,000.00
Нийт дүн						792,031,100.00 (долоон зуун ерэн хоёр сая гучин нэгэн мянга нэг зүүн)